



УЛААНБААТАР ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-Д

**УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жигжиджавын гудамж 9, Хангарди ордон,
Утас/Факс: (976-11) 31 53 47, И-мэйл: ubzaa@ubservice.mn,
Вэбсайт: www.ubservice.mn

2021.10.14 № 01/2644
танай _____-ны № _____-т

**Захирамжийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай**


Нийслэлийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/785 дугаар захирамжаар Улсын Их хурлын 28 дугаар тойргийн нөхөн сонгуулийн нэмэлт санал авах, хяналтын тооллого хийхтэй холбогдуулан нийслэлийн нутаг дэвсгэрт 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр зогсоох шийдвэр гарсныг хавсралтаар хүргүүллээ.

Иймд захирамжийн хэрэгжилтийг хангаж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдье.

Хавсралт 2. хуудастай.

Хувийг: хавсралтад дурдсан байгууллагуудад

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАРТ

НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН УДИРДАХ ГАЗАРТ

ТӨВИЙН 6 ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАРТ

НИЙСЛЭЛИЙН СПОРТ ХОРООНД

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-Д

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ТӨХК-Д

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ-Т

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАРТ



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/785

Улаанбаатар хот

**Монгол Улсын Их хурлын сонгуулийн
тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны 40 дүгээр тогтоол, Сонгуулийн Ерөнхий хорооны 2021 оны 105 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын Их Хурлын 28 дугаар тойргийн нөхөн сонгуулийн нэмэлт санал авах, хяналтын тооллого хийхтэй холбогдуулан нийслэлийн нутаг дэвсгэрт 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр зогсоосугай.

2.Улсын Их Хурлын нөхөн сонгуулийн нэмэлт санал авахтай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгасугай:

2.1.соёл, урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг нийслэлийн Соёл, урлагийн газар (Ж.Дамдинцэрэн), нийслэлийн Спортын хороо (Ж.Ганболд), холбогдох бусад аж ахуйн нэгж, байгууллагуудад;

2.2.гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвүүдийн тухайн 7 хоногийн амралтын өдрийг сонгуулийн санал авах өдөр буюу 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөрт шилжүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авахыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;

2.3.холбогдох хууль, журам, Сонгуулийн Ерөнхий хорооноос тавьсан шаардлагыг хангаж, коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням), нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж), нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчулуун), нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал), дүүрэг, хорооны Засаг дарга нарт;

2.4.сонгуулийн хороо, санал авах байрны хэвийн ажиллах нөхцөл, бололцоог бүрдүүлэх зорилгоор телефон утас, цахилгаан эрчим хүч, усан хангамжаар тасралтгүй, найдвартай хангаж ажиллахыг "Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК (Р.Дагдан), "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК (Ч.Золбаяр),

111920003719

“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (Ц.Төрхүү)-т, нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар (Ч.Сайханбаяр)-т;

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал), нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчулуун), дүүргийн Засаг дарга нарт, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Т.Гантөмөр), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Т.Оюунчимэг)-т, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул)-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

